

Байгууллагын үйл ажиллагаа, үр
дүнг үнэлж дүгнэх журам"-ын
1 дүгээр хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ЦАГЛАБАР

Д/д	Байгууллагын үйл ажиллагааны үзүүлэлт	Давтамж	Тайлагнах байгууллага	Үзүүлэлтийг дүгнэх байгууллага	Тайлан хүргүүлэх хугацаа	
					Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт	Засгийн газар, УИХ-д хүргүүлэх

0	1	2	3	4	5	6
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	Хагас жил тутам	Яам, аймаг, нийслэл, бусад байгууллагууд	Тухайн байгууллага	01 дүгээр сарын 02-ны өдрийн дотор, 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор	-Засгийн газарт 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор, 09 дүгээр сард; -Улсын Их Хурлын Тамгын газарт 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор
2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	Хагас жил тутам цахим системээр			02 дугаар сарын 01-ний өдрийн дотор	Засгийн газарт 04 дүгээр сард
3	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	Жил тутам				
4	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (ил тод байдал, шилэн дансны үнэлгээ)	Жил тутам				
5	Төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн		Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар			
6	Хэрэглэгчийн үнэлгээний дүн					
7	Үнэлгээ, хяналт-шинжилгээний мэргэжил, арга зүйн зөвлөгөөний хэрэгжилт					

0	1	2	3	4	5	6
8	Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээ	Жил тутам	Төрийн албаны зөвлөл			
9	Хүний нөөцийн үйл ажиллагаан дахь чадахуйн зарчмын хэрэгжилт					
10	Байгууллагын шударга байдлын үнэлгээ		Авлигатай тэмцэх газар		03 дугаар сарын 15-ны өдрийн дотор	
11	Санхүүгийн аудитын дүгнэлт		Үндэсний аудитын газар			

“Байгууллагын үйл ажиллагаа, үр
дүнг үнэлж дүгнэх журам”-ын
2 дугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны эхний хагас жилийн байдлаар

	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл, заалтын дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээг үй шалт гаан	Хянал таас хасах үндэс лэл
--	--------------------------	----------------------------	-----------------------	----------------------	------------------------------	--

1	2	3	4	5	6	7	8
				Монгол Улсын Хууль			
1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай	8.2.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийн талаарх мэдээллийг газрын www.namem.gov.mn цахим хуудасны Бидний тухай цэсэд байршуулсан.	70		
	2021.12.17	8.2.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт болон хэлтсүүдийн албан хаагчдын утас, и-мэйл хаягийг газрын www.namem.gov.mn цахим хуудасны Бидний тухай цэсэд байршуулсан.	70		

1	2	3	4	5	6	7	8
		8.2.7.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Хэрэгжилт удаашралтай, гүйцэтгэл хангалтгүй байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд бодит үр дүнг нэмэгдүүлэх зөвлөмжийг газрын www.namem.gov.mn цахим хуудасны Бидний тухай цэсэд байршуулсан.	70		
		8.2.8					
		8.3.1.	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтуудыг газрын www.namem.gov.mn цахим хуудасны Ил тод байдал цэсэд байршуулсан.	70		
		8.3.2.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	2025 оны хагас жилийн байдлаар байгууллагад 18 өргөдөл ирсэн. Үүнээс бичгээр 5 өргөдөл, 13 өргөдөл нь цаг агаарын мэдээ авах хүсэлт байсан. Эдгээр өргөдлийг хүлээн авч бүртгээд хуулийн хугацаанд 100 хувьтай шийдвэрлэж хариуг эзэнд нь мэдэгдэв. Аймгийн 70321111 утсаар ирсэн гомдол мэдээлэл байхгүй. Өргөдөл гомдлын тайлан мэдээг улирал тутамд гаргаж өгч байгаа. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг газрын www.namem.gov.mn цахим хуудасны Ил тод байдал цэсэд байршуулсан.	70		
			Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	Ажлын байрны сул орон тоо байхгүй	70		

1	2	3	4	5	6	7	8
		8.3.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	Ажлын байрны сул орон тоо гараагүй учир сонгон шалгаруулалт явагдаагүй	70		
			Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	Албан хаагчийн ёс зүйн дүрэм” болон дотоод журмыг газрын www.namem.gov.mn цахим хуудасны ил тод байдал цэсэд байршуулсан.	70		
		8.3.3	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл.	Хугацаа болоогүй	70		
		8.4.1	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан.	Хугацаа болоогүй	70		
		8.4.2.					
		8.4.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт.	2024 оны Санхүүгийн тайланд Аудит шалгалт хийж зөрчилгүй дүгнэлт авсан.	100		
		8.4.4.	хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний мэдээлэл.	Тус төвийн байгаль орчны шинжилгээний лаборатори нь 2025 онд 500 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 1,848.6 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 369,72 хувиар давуулан биелүүлсэн.	70		
		8.4.5.					
		8.4.6.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	2025 оны хагас жилийн байдлаар батлагдаж ирсэн төсөв зориулалтын дагуу зарцуулагдсан.Төсвийн хэмнэлт хэтрэлт гараагүй.	70		
			Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг	Таван саяаас дээш гүйлгээ хийгдээгүй	70		

1	2	3	4	5	6	7	8
		8.4.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Таван саяаас дээш гүйлгээ хийгдээгүй	70		
		8.4.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансны мэдээлийг 4 бүлгийн 28 үзүүлэлтээр сар бүр тодорхой бөглөж 2025 оны 06 дугаар сарын 19-ний байдлаар нийт мэдээллэх 171 мэдээллээс 67 мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан. Батлагдсан төсвийн хуваарь, хагас жилийн санхүүгийн тайлан, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өглөг авлагын дэлгэрэнгүй мэдээ, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт зэргийг тухай бүр шинэчлэн оруулж, байгууллагын мэдээллийн самбарт цаасан хэлбэрээр байршуулан ил тод нээлттэй мэдээлэн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж ирсэн ба БОУАӨЯаманд улирал бүр шилэн дансны хөтлөлтийн тайланг дараа сарын 15-н дотор цахимаар явуулсан.	70		
	Хэсгийн дундаж 72,1 хувь						
	Улсын Их Хурлын тогтоол						
2		2016_51	Шинэ боловсон хүчин сонгон шалгаруулж				

1	2	3	4	5	6	7	8
	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2016-11-03	3.1-р зорилтын хүрээнд:	авахдаа сонирхолын зөрчилгүй, мэргэжлийн боловсон хүчнээр хангах Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ил тод,нээлттэй,хариуцлагатай албан хаагч, албан тушаалтан болон хөгжүүлэх	Албан хаагчдад 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу чадавхжуулах сургалт салбар тус бүрд зохион байгуулсан. Үйл ажиллагааны чиглэлээс шалтгаалан авилга ашиг сонирхолын зөрчилд холбогдох асуудал гардаггүй. Төвийн дарга, цаг уур орчны технологийн хэлтсийн дарга, захиргаа аж ахуйн хэлтсийн дарга, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч гэсэн 5 хүн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлсэн. Орон нутгаас зохион байгуулж байгаа Авилгын эсрэг соён гэгээрүүлэх сургалт Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг цахим сургалтуудад албан хаагчдыг хамруулж хэвшсэн. 2025 оны 02 дугаар сард Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах ЦАХИМ сургалтад ЦУОТХ-ийн дарга, хүний нөөцийн мэргэжилтэн, 01 дүгээр сард Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт сургалтад 5 албан хаагч хамрагдсан.	70		

1	2	3	4	5	6	7	8
		3.2-р зорилтын хүрээнд:	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангах ажил үйлчилгээний дагуу байгууллага иргэдэд тухай бүр мэдээ, мэдээллээр үйлчилж ажилласан. Цаг агаарын мэдээ, мэдээлийн тухай 415 иргэдээс санал асуулга авсан. Оролцогсдын 86.3 хувь нь цаг агаарын мэдээг тогтмол хүлээн авч ашигладаг ба тэдний 90,1 хувь нь телевиз болон цахимаар, 47.1 хувь нь цаг уурын салбараас авдаг байна. Оролцогсдын 92.2 хувь нь мэдээг сайн таардаг, 7.8 хувь нь ихэвчлэн таардаг, 95.5 хувь нь цаг агаарын мэдээг ойлгомжтой гэсэн бол 89.8 хувь нь цаг агаарын мэдээг хэрэгцээ шаардлагыг хангаж байна гэж тодорхойлсон байна. Цаг уурын байгууллагын цахим хуудсыг санал асуулгад оролцогсдын 94.5 хувь нь тогтмол ашигладаг, 3.4 хувь нь огт ашигладаггүй, 2.1 хувь нь хаяа ашигладаг гэсэн дүн гарсан байна.	70		
3	“АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020-05-13	НЭГ. Үндэсний нэгдмэл үнэт зүйл: 2020_52 1.3 Монгол бичиг	Хүн бүр эх хэлний боловсролыг дээшлүүлэх, бүх шатны сургалтын байгууллагад монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлэх Монгол хэл бичгийг нийтээр болон гадны иргэд эзэмших таатай нөхцөл	2025 оны 1 дүгээр сарын 01-ээс төрийн байгууллагууд хос бичгээр албан хэргээ хөтлөх гэж байгаатай холбогдуулан 2024 оны 11 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 12-ны хооронд төрийн албан хаагчдын үндэсний бичгийн сургалтад байгууллагаараа хамрагдаж 2025 оны 05 дугаар сард ЗДТГазраас зохион байгуулсан монгол бичгийн шат дараалсан шалгалтын эхний түвшний шалгалтад албан хаагчид хамрагдсан болно.	70		

1	2	3	4	5	6	7	8
			бүрдүүлж, нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвших, албан хэргийг хос бичгээр хөтлөх				
		Зорилт 2	Иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийтийн эрүүл мэнд тусламж үйлчилгээний үндэсний тогтолцоо бүрдүүлэх, амьдралын зөв дадал, хэвшлийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх	Албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлийг эрт илрүүлэх амьдралын зөв дадал, хэвшлийг дэмжих, тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр эрт илрүүлгийн хөтөлбөрт албан хаагчдад цалинтай чөлөө олгож хамруулсан. Эрүүл байх гол үндэс болох идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих үүднээс Спорт хамтлагийн комиссыг тушаалаар томилж, албан хаагчдыг идэвхжүүлж ажилласан. Байгууллагын Спорт хамтлаг санаачлага гаргаж 7 хоног бүрийн 3 дахь өдөр спорт заалтай гэрээ байгуулж гар бөмбөг, сагсан бөмбөг тоглох, хөгжөөнт тэмцээх зохион байгуулж албан хаагчдын ирцийг бүртгэж хүн бүрийг хамруулж ажиллаж байна.	70		
		Зорилт 3	Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлэх, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжих, нийгмийн идэвхтэй, бүтээлч гэр бүлийг дэмжих орчинг бүрдүүлэх	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан Эцэг эхийн зөвлөгөөнд 2 албан хаагч хамрагдаж, байгууллагын албан хаагчдад “Гэр бүлийн үнэ цэн” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Гэр бүлийн зөвлөлөөс Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдийн дунд хөгжөөнт тэмцээн зохион байгуулж, хүлээн авсан. Олон улсын Гэр бүлийн өдрийг угтан “Миний гэр бүл миний аз жаргал” хүндэтгэлийн арга хэмжээнд албан хаагчдыг идэвхтэй хамруулж, гэр бүлийн өдөрлөг зохион байгуулсан.	70		

1	2	3	4	5	6	7	8
		Зорилт 4	Авилга ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлсэн, авлигатай бүх нийтээр тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны чиглэлээс шалтгаалан авлига ашиг сонирхлын зөрчилд холбогдох асуудал гардаггүй. Төвийн дарга, Цаг уур орчны технологийн хэлтсийн дарга, Захиргаа аж ахуйн хэлтсийн дарга, Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч гэсэн 5 хүн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлсэн. Орон нутгаас зохион байгуулж байгаа Авлигын эсрэг соён гэгээрүүлэх сургалт Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг цахим сургалтуудад албан хаагчдыг хамруулж хэвшсэн. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төвийн бүсийн 3 аймгийн албан хаагчид оролцсон “Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, хууль тогтоомжийн хэрэгжилт” сургалтад 1 албан хаагч хамрагдсан. 2025 оны 02 дугаар сард Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах ЦАХИМ сургалтад ЦУОТХ-ийн дарга, хүний нөөцийн мэргэжилтэн, 01 дүгээр сард Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт сургалтад 5 албан хаагч хамрагдсан.	70		
		Зорилт 5	Мэдээлэл харилцаа холбооны технологийн дэвшил инновацыг нэмэгдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим мэдээлийн нэгдсэн санд бүрэн шилжих	“Цахим шилжилтийг эрчимжүүлэх жил” болгон зарласан хэлэлцүүлэг, сургалт, семинарт УЦУОШТөвийн 9 албан хаагч хамрагдсан. Тус ажлын хүрээнд “Цаг уур орчны шинжилгээний газраас 2 сургалт цахимаар авсан. Орон нутаг болон бусад чиглэлийн 2 сургалтад цахимаар хамрагдсан. Байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулсан цахим сургалт сурталчилгаа: Үүнд Өртөө, харуулын ажилтнуудад ЦАХИМ хэлбэрээр улирлын чанартай 3 удаагийн сургалт, Уур амьсгалын инженерүүдийн чадавхыг сайжруулах цахим сургалт Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл Хөдөө аж ахуйд сэдэвт сургалт семинар Гамшгийн эрсдлийн удирдлагын сургалт семинар Нислэгийн цаг агаарын мэдээний хангалт, ашиглалтын талаарх цахим сургалт, хурал	70		

1	2	3	4	5	6	7	8
				Өртөө, харуулын албан хаагчдад мэргэжлийн мэдлэг дээшлүүлэх чадавхжуулах онлайн сургалт Улирлын чанартай ажиглалтуудаар (Цаг уур, Хөдөө аж ахуйн цаг уур) явуулсан байна.			
4	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-04-18	2024_27	Зорилго 1 Зорилго 2 Зорилго 3 Зорилго 4	УЦУОШТөв нь 85 албан хаагчтай. 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/16 дугаар тушаалаар ёс зүйн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллаж байна. Ажиллах хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. Орон нутаг болон Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахим сургалтад тус хорооны дарга болон гишүүд бүрэн хамрагдсан. Цаашид байгууллагын нийт албан хаагчдын саналыг үндэслэн ёс зүйн дэд хорооны гишүүдийг шинэчлэх төлөвлөгөөтэй байна.	70		
Хэсгийн дундаж 70 хувь							
Засгийн Газрын тогтоол							
5	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2021.350	Цөлжилт, газрын доройтол, шороон шуурганы эх үүсвэрийг бууруулах, элсний нүүлтийг сааруулах	“Баян Намсрай” шинэ цэцэрлэгт хүрээлэнд аймгийн төрийн албан хаагчид 10 гаруй мянган хайлаас мод тарих ажлын хүрээнд тус төвийн нийт албан хаагчид 77 ширхэг хайлаасыг авч тарьсан ба 60 модны нүх ухаж бэлтгэсэн. Үүнд зориулж ажилчдын хандиваар модны нүх ухах багаж 350,000 төгрөгөөр худалдан авсан. Бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд зохион байгуулж буй арга хэмжээнд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцож байна.	70		
	2021-11-17	Зорилт 8:	Төв суурийн газрын ногоон байгууламж, өрхийн жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх замаар агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, эрүүл амьдрах таатай	Ус судлалын салбарын хамт олон Онги-Таац сав газрын захиргаатай хамтран Нарийнтээл сумын “Таац-Нарийнтээл” Ус судлалын харуулын байрны эргэн тойронд тарьсан шар хуайс 123 ширхэг, буйлс 2 ширхэг, голт бор 6 ширхэг, монос 8 ширхэг, шинэс модыг жил бүр арчлан тордож, ургуулж байна. Модыг гадны нөлөөнөөс хамгаалж хашсан.	70		

1	2	3	4	5	6	7	8
			орчин нөхцлийг бүрдүүлэх				
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр 2017-08-31	2017.243	2.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг боловсронгуй болгож, уялдаа холбоог сайжруулна	Ус цаг уур орчны хяналт шинжилгээний ажилд мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журмыг салбар бүрд хэвлэн хүргүүлж, хяналт тавьж ажиллалаа. Салбаруудын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулж бүх ажилтнуудыг хамруулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандарт, норм, дүрэм, журмын хэрэгжилтийн хяналтыг Дотоод хяналтын хэсэгтэй хамтран давхардсан тоогоор 21 салбарт 2 удаа хийж ажилласан. БОХЗТЛабораторит 6 төрлийн химийн болон хортой бодисыг татан авч шинжилгээний ажилд ашиглаж байгаа ба бүх төрлийн химийн бодисын хадгалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллаж байна. ЦАЗНөлөөлөх хэрэгсэл ашиглах тусгай зөвшөөрлөө 2026 он дуустал сунгуулсан. Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны А/26 тушаалыг үндэслэн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 3 дугаар сарын 31-ний А/04 тушаалаар ЦАЗНөлөөлөх бие бүрэлдэхүүнд томилгоожилт хийсэн. Экспедицийн бие бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны заавар дүрмийг нэг бүрчлэн танилцуулж, гарын үсэг зуруулан ажилласан. Мөн цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд оролцох албан хаагчдын гарын үсгийн баталгааг гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.	70		
			3.6.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлж, арга зүйн удирдлагаар хангах	ЦАЗНөлөөлөх экспедицийн бие бүрэлдэхүүн болон БОШЛ-ын ажилтнуудад Өвөрхангай аймгийн Цэргийн штаб, Тагнуулын газрын мэргэжилтнүүд 2025 оны 02-р сарын 15-нд Тэсэрч дэлбэрэх бодис тээвэрлэх, хамгаалах, аюулгүй ажиллагаа болон үйл ажиллагааны талаар мэргэжлийн сургалтыг хийсэн. 2024 оны үлдэгдэл 15 ширхэг пуужин, 2025 оны 03р сард ЦУОШГазраас 20 ширхэг пуужин авч нийт 35 ширхэг пуужингаас цаг агаарт	70		

1	2	3	4	5	6	7	8
				зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд 3 дугаар сард 2 удаа 6 ширхэг пуужин, 4 дүгээр сард 1 удаа 2 ширхэг пуужин, 5 дугаар сард будаа 14 ширхэг пуужин ба 66 грамм регентийг үүлэнд зориудаар нөлөөлж үйл ажиллагааг явуулсан байна. 3,4,5 дугаар саруудад 22 ширхэг пуужин зарцуулсан. 13 пуужин зэвсгийн агуулахад горимын дагуу хадгалж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээ нийт өртөө харуулын ажилчин, албан хаагчдад үр дүнтэй хэрэгжиж, эрүүл, аюулгүй орчин нөхцөлд ажиллаж, амьдрах зан үйл төлөвшсөн.			
7	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2010-06-02	2010.141	2.3.7. интернэтийн аюулгүй байдлыг хангах	Төвийн болон сумдын өртөө, харуулуудын компьютерт лицензтэй вирусны хамгаалалт “Kaspersky, internet security” суулгаж, интернэтийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Тухайн вирусны программд тогтмол хуваарийн дагуу UPDATE хийлгэдэг. Firewall-ыг байнгын идэвхтэй горимд байлгадаг. Ажилчдыг тодорхой бус хаяг линк рүү орохоос сэргийлж урьдчилан сэргийлэх үүднээс зөвлөмж хүргүүлж ажиллаж байна.	70		

1	2	3	4	5	6	7	8
8	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр 2006-04-03	2006_64	2.4.3. Архивын салбарт мэргэжлийн боловсон хүчнээр хангах	Архив мэдээллийн дэд сангийн ерөнхий зохицуулагч 2008 оноос бие даасан орон тоогоор ажиллаж улсад системдээ 99.96% “А” үнэлгээтэй дүгнэгдсэн. Ажлаа улирал жилээр нь төлөвлөн тухай бүрд нь үнэлүүлж дүгнүүлэн, харьяа дээд байгууллагаас шаардсан тайлан дүнг заасан хугацаанд нь 100 % хүргүүлсэн.	70		
			3.2.6. Төрийн архивын тоо бүртгэл, мэдээлэл, эрэлт хайлтын цахим тогтолцоог бүрдүүлэх	Архивын баримтын бүртгэл, эрэлт хайлтын “ADRSS”, автомат станцын мэдээлэл боловсруулалтын “AWS” программуудыг бүрэн гүйцэт ашиглаж архивд байгаа цаасан суурьтай бүх материалыг программд бүртгэсэн ба 2024 оны 108 хн бүхий 16053 хуудас цаасан суурьтай материал шинжилгээний ажлын материалыг хүлээж авсан. 2024 оны эхний хагас жилийн Уур амьсгалын тайлан 44.5mb 497 файл, AWS-ийн мэдээ 470 mb 2885 файл мэдээнүүдийг тухай бүрд хугацаанд нь хүлээн авч цахим сан үүсгэж ажиллаж байна. Архивын цахим баримтын 5 хадгаламжийн нэгж хүлээж авсан.	70		
9	Журам, жагсаалт, хуваарь батлах тухай 2015-07-07	2015_286	Тогтоолын 1 дүгээр хавсралт: Ус цаг агаар, орчны аюултай, гамшигт үзэгдлийн талаар урьдчилан сэргийлэх мэдээ дамжуулах журам	Цаг агаарын бүх төрлийн урьдчилсан мэдээгээр үнэн зөв, аль болох урт хугацааны урьдчилалтай орон нутгийн удирдлага, аж ахуй нэгж, ард иргэд, малчид тээвэрчдэд багц мессеж үйлчилгээгээр давхардсан тоогоор 139816 удаа үйлчилсэн. Аюултай үзэгдэл ажиглагдах нөхцөл бүрдсэн тохиолдолд Сэрэмжлүүлэг мэдээг 16 удаа, урьдчилан сэргийлэх мэдээ 1 удаа, хоног, хагас болон 5 хоногийн урьдчилсан мэдээг өдөр бүр, 7 хоногийн мэдээг тухай бүрд нь мөн бүх төрлийн мэдээ мэдээллээр 18	70		

1	2	3	4	5	6	7	8
				сумын ЗДТГазарт 198 удаа, ОБГазарт 182 удаа, зам тээврийн үйл ажиллагаанд 31 удаа, хэвлэж тараасан 186 удаа, утсаар 386 удаа, орон нутгийн тв сайт болох uvlive.mn, unn.mn сайтуудад 5 удаа гаргаж мэдээ мэдээллээ ард иргэдэд өдөр бүр цахимаар хүргэж үйлчилсэн. цаг агаарын бүх төрлийн урьдчилсан мэдээ, СМ-г тухай бүрд нь гаргаж http://uvurkhangai.weather.gov.mn/ www.facebook.com/ӨвөрхангайУсЦагУур/ хаягаар тогтмол тавьж, Facebook болон утсаар аймгийн удирдлагуудад, телевизээр нийт ард иргэдэд хүргэсэн.			
10	Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2017-05-02	2017_134	Газар тариалангийн бүс нутаг болон ой, тал хээрийн зарим нутгаар агаарын хуурайшлын зэрэг эрчимтэй нэмэгдсэнээс ой, хээрийн түймэр гарах нөхцөл бүрдэж, цаашид гамшгийн түвшинд хүрч болзошгүй байгаатай холбогдуулан цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх зориулалтын пуужин, газрын генераторын түлшийг шууд гэрээ байгуулах аргаар худалдан авч, хур тунадас нэмэгдүүлэх ажлыг 2017 оны 6 дугаар сарын 10-ны дотор шуурхай зохион байгуулахыг Цаг уур,	Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны А/26 тушаалыг үндэслэн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргын 2025 оны 3 дугаар сарын 31-ний А/04 тушаалаар ЦАЗНөлөөлөх бие бүрэлдэхүүнд томилгоожилт хийсэн. Экспедицийн бие бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны заавар дүрмийг нэг бүрчлэн танилцуулж, гарын үсэг зуруулан ажилласан. Мөн цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд оролцох албан хаагчдын гарын үсгийн баталгааг гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн Онги-Бороо 1,2 экспедиц нь 2025 он 03-р сарын 13-нд Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг эхлүүлсэн. 03-05 дугаар сард 9 процесст нийт 21 ширхэг пуужин зарцуулсан. 03-05 дугаар сарын орж ирэх процессууд дээр ECMWF загвар буюу Европын дунд хугацааны прогнозоор өгсөн хур тунадасны хэмжээ илүү таарцтай байсан. 06 дугаар сарын 01-ний байдлаар Орхон голын усны түвшин 8-10 см-ээр, Онги голын усны түвшин 8-11 см-ээр, Таац голын усны түвшин 3-6 см-ээр тус тус нэмэгдсэн байна. Аймгийн нийт нутгаар 2025 оны 05 дугаар сард 565.4 мм хур тунадас орсон ба ОЖД-аар 229.3 мм тунадас ордог ба Баянгол, Уянга сумдын нутгаар дунджийн орчим тунадас орсон бол бусад нутгаар дунджаас 4.0-43.0 мм-ээр ахиу тунадас орсон хэдий ч 05-р сарын агаарын	70		

1	2	3	4	5	6	7	8
			орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшинд даалгасугай.	дундаж температур 11.1 градус байсан нь зарим сумдаар дунджаас хүйтэн температуртай байсан нь ургамал ургахад төдийлөн тааламжтай нөхцөл бүрдээгүй учир нийт нутгийн 70 гаруй хувьд ургамлын ургалт дунд, 20 гаруй хувьд сайн, 5 орчим хувьд муу байна. Ургамлын дундаж өндөр 3-12см байна.Санхүүжилтийн хувьд: 03-05 дугаар сард Өвөрхангай аймгийн нутгаар 9 удаагийн процесс дээр хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг амжилттай явуулсан. Нийт 495750км.кв нутаг дэвсгэрт 10390286м3 тунадас нэмэгдүүлж 136517674 (нэмэгдүүлсэн усны өртөг), 21 ширхэг пуужин (11761302 төгрөг), 1650 км замыг туулж (989800 төгрөгийн шатахуун), 1590000 төгрөг (томилолт). ПУУЖИН, ШАТАХУУН, ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛД 15025664 төгрөг зарцуулсан. Өвөрхангай аймгийн ЗДТГ-аас Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд 38.5 сая төгрөг шийдвэрлэсэн.			
11	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22	2018_258	1.1. Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх; 1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар	Төрийн Албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тогтоолын дагуу Ёс зүйн хорооноос байгууллага дээр болон томилолтоор яваад ирэх хүртэл томилолтын хугацаанд архидан согтуурах үед шууд халах хүртэл арга хэмжээ авах талаар бүх албан хаагчдын хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Аливаа баяр ёслол тэмдэглэлт өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн хуваарь баталж сахилга хариуцлага, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан. Технологийн болон гэмт хэрэг, ёс зүйн зөрчилгүй ажиллаж байна..	70		
					70		

1	2	3	4	5	6	7	8
			ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;				
12	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024-12-25	2024_238	Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын цалингийн доод хэмжээ	10-р хавсралтын дагуу ажилчдын үндсэн цалинг, цалингийн сүлжээний дагуу олгож байгаа ба төрийн албанд алба хаасан хугацааны нэмэгдлийг 1-25 хувиар 77 ажилтанд 62,656,6 мян/төгрөг, мэргэжлийн зэргийг 10-20 хувиар 38 ажилтанд 29.794,6 мян/төг, төвийн даргын тушаалаар ур чадварын нэмэгдлийг 10-25 хувиар 29 хүнд 36.956,8 мян.төгрөг, мөнгөн урамшуулал 3,436.0 мян.төгрөгийг ажлын үр дүнг харгалзан олгосон. 32 хүнд шөнө хоногийн хөлсөнд 16.096,0 төгрөг, 25 хүнд илүү цаг, нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлсөнд 14.971.8 мян.төгрөгийг тус тус олгосон.	70		
	Хэсгийн дундаж 70,0 хувь						
	Нийт дундаж 70.7 хувь						

Хэрэгжилтийг хянасан:

УЦУОШТөвийн дарга
(албан тушаал)

Ч.Чанцалдиймаа
(гарын үсэг)
тамга, тэмдэг

/...../
(огноо)

Хэрэгжилт тайлагнасан:

ЗААХэлтэс
(албан тушаал)

Б.Гантулга.....
(гарын үсэг)

/...../
(огноо)

“Байгууллагын үйл ажиллагаа, үр
дүнг үнэлж дүгнэх журам”-ын
3 дугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ТӨРИЙН
АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР)**

Д/д	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилто т	Хүрсэн	Тайлбар
1	2	3	4	5	6	7
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (дотоод сургалт)	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	33	8 сургалт хугацаа хойшлогдсон. Гүйцэтгэл 75.7	Зорилтот түвшин хэсэгт байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгасан дүнг бичнэ. 1.Зөвхөн сертификаттай сургалт болон 4-өөс дээш цагийн сургалтыг тайлагнана. (холбогдох материалыг хавсаргах)
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	25	25	
			Мэргэшүүлэх сургалт	11	04 дүгээр сарын 28-30-нд 1 ажилтан Шалгалт тохируулгын эрх олгох сургалт, 05 дугаар сарын 14-16-нд шинээр суурилуулах Аэрологийн станцын сургалтад 7 ажилтан, Удирдлагын академын Удирдах ажилтны ур чадвар, манлайлал сургалт 1 ажилтан, Иргэний агаарын тээврийн нислэгт үйлчлэх эрхийн сургалт 2 ажилтан, Дэлхийн цаг уурын байгууллагын синоптик инженерүүдийн чадавхийг сайжруулах бүсийн сургалт 1 ажилтан, Зөвсгийн инженерүүдийн Пиротехникийн нөхцлийн сургалтад 4 ажилтан, 30 албан хаагч Үндэсний бичгийн анхан шатны мэргэшүүлэх сургалтад хамрагдсан. Үнэмлэхийг хавсаргав.	
			Туршлага солилцох арга хэмжээ	2	Цаг уурын 7 өртөө, 11 харуул, Ус судлалын 7 өртөө, 3 генератор 03 дугаар сард туршлага судлах сургалт, Увс, Хөвсгөл, Улаанбаатар УЦУОШТөвийн Аэрологийн инженер, техникийн ажилтнууд 05 дугаар сарын 14-16-нд туршлага судлах, арга зүй сурталчлах сургалт	
			Бусад	12	УЦУОШТөвийн сургалтын өрөөнд хугацаандаа хийгдсэн.	
		1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	85	83	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	57	52	

1	2	3	4	5	6	7
			Эрэгтэй албан хаагч	28	23	
			Удирдах албан тушаалтан	1		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	84	74	
		1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	99.1 хувь		
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан (гадаад сургалт)	2.1	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	2		2.Гадаад улс орон, хилийн чанадад хамрагдсан сургалтыг тайлагнана. (холбогдох материалыг хавсаргах)
		2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	2		
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	1	Цаг уурын салбарын хамтын ажиллагааны 11 дүгээр протоколын албан ёсны уулзалт БНСУ-ын Сөүл хотноо 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр амжилттай зохион байгуулагдсан. Энэхүү уулзалтад төлөөлөгчөөр тус төвийн дарга Ч.Чанцалдиймаа оролцсон.	
			Эрэгтэй албан хаагч	1	Дэлхийн цаг уурын байгууллагын синоптик инженерүүдийн чадавхыг сайжруулах бүсийн сургалт 05 дугаар сарын 23-нд БНСУ-д зохион байгуулагдсан.Тус сургалтад УЦУОШТөвийн синоптик инженер Б.Цэрэндагва оролцсон.	
			Удирдах албан тушаалтан	1	Цаг уурын салбарын хамтын ажиллагааны 11 дүгээр протоколын албан ёсны уулзалт БНСУ-ын Сөүл хотноо 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр амжилттай зохион байгуулагдсан. Энэхүү уулзалтад төлөөлөгчөөр тус төвийн дарга Ч.Чанцалдиймаа оролцсон.	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	1	Дэлхийн цаг уурын байгууллагын синоптик инженерүүдийн чадавхыг сайжруулах бүсийн сургалт 05 дугаар сарын 23-нд БНСУ-д зохион байгуулагдсан.Тус сургалтад УЦУОШТөвийн синоптик инженер Б.Цэрэндагва оролцсон.	
		2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал:	2	Цаг уурын салбарын хамтын ажиллагааны 11 дүгээр протоколын албан ёсны уулзалт БНСУ-ын Сөүл хотноо 2025 оны 5	

1	2	3	4	5	6	7
					дугаар сарын 20-ны өдөр амжилттай зохион байгуулагдсан. Энэхүү уулзалтад төлөөлөгчөөр тус төвийн дарга Ч.Чанцалдиймаа оролцсон. Дэлхийн цаг уурын байгууллагын синоптик инженерүүдийн чадавхыг сайжруулах бүсийн сургалт 05 дугаар сарын 23-нд БНСУлсад зохион байгуулагдсан.Тус сургалтад УЦУОШТөвийн синоптик инженер Б.Цэрэндагва оролцсон.	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал	3.1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	9 албан хаагчдад мэргэшүүлэх сургалтын зардал 1.500 төгрөг олгосон /томилолт, унааны зардал/		
4	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	4.1	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь (15%-аас доош байх)	$\frac{\text{чөлөөлөгдсөн албан хаагч}}{\text{албан хаагчдын дундаж}} * 100\%$		
		4.2	Шатлан дэвшүүлсэн албан хаагчийн тоо	2	Арвайхээр өртөөний дарга Ц.Энхзаяа, ХААЦУ-ын судалгааны инженер Б.Жанчив	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	2		
			Эрэгтэй албан хаагч	=		
			Удирдах албан тушаалтан	=		
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	2		
		4.3	Шилжүүлсэн болон сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо	=	=	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	=	=	
			Эрэгтэй албан хаагч	=	=	
			Удирдах албан тушаалтан	=	=	
Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	=		=			
Нийгмийн баталгааг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ						
5.	Албан хаагчид олгосон цалин урамшуулал, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг 5.1.Улирлын урамшуулал олгосон байдал	Нийт албан хаагчийн тоо		85	85	
		Урамшуулал олгосон албан хаагчийн тоо		85	84	
		Үүнээс	Удирдах	1		
			Гүйцэтгэх	84		
		Нийт олгосон урамшууллын хэмжээ		114,831.0	91.628,9	
		Үүнээс	I улирал			
			II улирал	95,692.5	91,628.9	
			III улирал			
			IV улирал			

1	2	3	4	5	6	7
		Цалингийн нийт санд эзлэх хувь		12%	Тус төвийн нийт цалингийн сангийн 12%-ийг урамшууллын зардал эзэлж байна.	
	5.2.Нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:	албан хаагчийн тоо-9		Тус төвийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох	Хагас жилийн байдлаар нийт 9 албан хаагчдад 1500,0 мянган төгрөгийн томилолт олгосон.	
		нөхөх төлбөрийн хэмжээ		1,500.0	1,500.0	
	5.2.1.албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2)		албан хаагчийн тоо	9	9	
			нөхөх төлбөрийн хэмжээ	1,500.0	1,500.0	
	5.2.2.албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин хэрэглэсний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 3.2)		албан хаагчийн тоо	=	=	
			нөхөх төлбөрийн хэмжээ	=	=	
	5.2.3.төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 5.1, 5.2)		албан хаагчийн тоо	=	=	
			нөхөх төлбөрийн хэмжээ	=	=	
	5.2.4.хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг, гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмчилгээний зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 7.1)		албан хаагчийн тоо	=	=	
			нөхөх төлбөрийн хэмжээ	=	=	
	5.2.5.Гадаад улс болон орон нутагт ажиллахаар томилогдсон төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 4.1)		БНСУлсад ажилтан (Улсын төсвөөр) 2			
			Орон нутагт ажилласан ажилтан 9			
	5.2.6.замын зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 6.1)		БНСУлсад ажилтан (Улсын төсвөөр) 2			
			Орон нутагт ажилласан ажилтан 9			
	5.3.бусад нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:		=	=		
			=	=		
	5.3.1.төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардал болон ажилдаа ирэх, буцахад нийтийн		85 ажилтан	Унаа хоолны хөнгөлөлт олгох	Хагас жилийн байдлаар нийт 85 албан хаагчдад унаа хоолны хөнгөлөлтөд 148,833.0 сая төгрөгийг олгосон.	

1	2	3	4	5	6	7
	тээврийн хэрэгслээр зорчсон нийтийн тээврийн унааны зардлын хэмжээ ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.2, 8.4)	85 ажилтан		148,833.0	148,833.0	
	5.3.2.ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.3)	=		=		
		=		=		
	5.3.3.төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тухайн албан хаагчийн албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.5)	=		=		
		=		=		
	5.3.4.Төрийн албан хаагчийг эрхэлсэн ажил, эзэмшсэн мэргэжлийн дагуу 180 хүртэл хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгоно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.6)	=		=		
		=		=		
	5.4.Төрийн албан хаагчид олгосон тусламж, нийт:			148,833.0		
	5.4.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан хаагчид олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж	=				
		=				
	5.4.2.албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас хохирсон албан хаагчийн ар гэрт олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж	=				
		=				
	5.5.төрийн албан хаагчийн нийтлэг баталгаанд зарцуулсан зардал, нийт:			148,833.0		
	5.5.1.ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй	=				

1	2	3	4	5	6	7
	албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон	=				
	5.5.2.орон байраар хангагдахад төрөөс үзүүлсэн дэмжлэг	=		=	Орон байрны нөхцөл сайжруулах -шинэ гэр, байшин авах -шинээр газар олгосон гэх мэт бодит дэмжлэгийн талаар бичих	
	5.5.3.албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг сайжруулахад зарцуулсан зардал	=		=		
		380,0		380,0	Арвайхээр өртөөний ажиглалтын талбай дахь 380кВт-ын цахилгааны эх үүсгүүрийн утас, кабель, автомат унтраалгыг сольсон.	




Хэрэгжилтийг хянасан:

УЦУОШТөвийн дарга Ч.Чанцалдиймаа
 (албан тушаал) (гарын үсэг) (огноо)
 тамга, тэмдэг

Хэрэгжилт тайлагнасан:

ЦУОТХ-ийн дарга Б.Отгондулам
 (албан тушаал) (гарын үсэг)
 (огноо)

Мэргэшүүлэх сургалтуудын үнэмлэхүүд





Тайлбар: Шалгалт тохируулгын ажилтны эрх олгох сургалт болон Пиротехникийн нөхцлийн сургалтын үнэмлэх ирж амжаагүй байна.

“Байгууллагын үйл ажиллагаа, үр
дүнг үнэлж дүгнэх журам”-ын
4 дүгээр хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЦУОШТӨВИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хэрэгжилтийн хувь	Жин
1	2	3	4
Бодлогын үр дүн	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүн	70	0.3
	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	=	
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ)	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	99.8	0.4
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	70.7	
Байгууллагын чадамжийн үнэлгээ	Хүний нөөцийн үйл ажиллагаан дахь чадахуйн зарчмын хэрэгжилт		0.2
	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	99.1	
	Ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээ		
	Санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт	100	
	Хяналт-шинжилгээний зөвлөмжийн хэрэгжилт	80.9	
Хөндлөнгийн болон оролцогч талуудын үнэлгээ	Төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн	90.8	0.1
	Байгууллагын шударга байдлын үнэлгээ	=	
	Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (ил тод байдал, шилэн дансны үнэлгээ)	100	
	Хэрэглэгчийн үнэлгээний дүн	90	
Нэмэлт оноо	Байгууллагын үйл ажиллагааны ерөнхий дүнгийн өөрчлөлт (+ оноо)	89.0	
Ерөнхий дүн:			1.0

---o0o---

“Байгууллагын үйл ажиллагаа, үр
дүнг үнэлж дүгнэх журам”-ын
5 дугаар хавсралт

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
..... ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хувь	Жин
1	2	3	4
Бодлогын үр дүн	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүн		0.3
	Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн дүн	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		0.4
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт		
Байгууллагын чадамжийн үнэлгээ	Хүний нөөцийн үйл ажиллагаан дахь чадахуйн зарчмын хэрэгжилт		0.2
	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт		
	Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээ		
	Санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт		
	Хяналт-шинжилгээний зөвлөмжийн хэрэгжилт		
Хөндлөнгийн болон оролцогч талуудын үнэлгээ	Төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн		0.1
	Ил тод байдлын болон шилэн дансны үнэлгээ		
	Байгууллагын шударга байдлын үнэлгээ		
	Хэрэглэгчийн үнэлгээний дүн		
Нэмэлт оноо	Байгууллагын үйл ажиллагааны ерөнхий дүнгийн өөрчлөлт (+ оноо)		
Ерөнхий дүн:			1.0

----o0o----